

## ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2017 оны 02 дугаар сарын 16

Дугаар 01

Налайх дүүрэг

Ашигт малтмалын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрчим хүчний тухай, Газрын хэвлийн тухай, Газрын тухай, Галын аюулгүй байдлын тухай, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиудын холбогдох заалтууд, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нэг талаас Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) Чойжинсамбуу овогтой Раднаабазар, нөгөө талаас тус дүүргийн 3 дугаар хорооны газарт ашигт малтмал ашиглах А/211 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) Сүмбэрхудаг компанийн захирал Алтанбилэг овогтой Мөнхбат, гуравдагч талаас бичил уурхайн Бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Нөхөрлөл” гэх)-үүдийн хяналтын ажилтан Чадраабал овогтой Энхбаатар нар харилцан тохиролцож хамтран ажиллахаар энэхүү “Хариуцлагын гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

### ***Нэг. Ерөнхий зүйл***

1.1. Өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаас нөхөрлөлд **нүүрс** олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Компани, Нөхөрлөлийн хоорондын үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа Төр, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны талаарх Монгол улсын хууль, тогтоомжийн хүрээнд хуулийг дээдлэн, байгууллага хоорондын харилцааны зохистой хэр хэмжээг баримтлан харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, талууд нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтлана.

### ***Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл***

2.1 Ашигт малтмалтай холбоотой хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг биелүүлэхийг шаардах

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нөхөрлөлөөс Засаг дарга дүүргийн татварын хэлтэст бүртгүүлж, албан татвар төлөхийг шаардах

2.3 “Гурвалсан гэрээ” байгуулахгүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эзэмшлийн талбайдаа бүртгэгдээгүй нөхөрлөл болон хувь хүмүүстэй хамтран үйл ажиллагаа явуулах эрх олгохыг хориглох

2.4 Нөхөрлөл нь “Гурвалсан гэрээ”-ээр олгосон газраас хэтэрч үйл ажиллагаа явуулахыг хориглох

2.5 Нөхөрлөл, хувь хүн бие даан тэсэлгээний ажил явуулахыг хориглох

2.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэж, дүүрэгт татвар төлөгчөөр бүртгүүлж, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх

2.7 Нөхөрлөлөөс нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг үйл ажиллагаанд оролцуулахыг хориглох

2.8 Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг зориулт бусаар ашиглахыг хориглох

2.9 Бичил уурхайн ажилтан бүрд бичил уурхайн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан зааварчилгаа өгөх;

2.10 Олборлолт явуулсан газарт хүн, мал, техник унаж гэмтэхээс хамгаалсан хаалт, далан байгуулах, тэсэлгээний цоног, ус зайлуулах суваг, шуудуу, малталт, усан сан зэрэгт таглаа, хаалт хамгаалалт хийх;

2.11 Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулах, өвчтэй буюу эрүүл мэндийн байдлаар ажиллах чадваргүй байгаа ажилтныг тухайн өдөр ажилд гаргахыг хориглох;

### ***Гурав. Гэрээг хэрэгжүүлэх талаар***

3.1 Талууд гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор “Гурвалсан гэрээ”-нд тусгасан ажлын тайланг хагас жил тутамд гаргаж, үр дүнг харилцан мэдээлж байна.

3.2 Энэхүү гэрээг талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

### ***Дөрөв. Харилцан хүлээх үүрэг***

4.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### ***Гэрээ байгуулсан:***

Налайх дүүргийн Засаг дарга

Сүмбэрхудаг компанийн Захирал

.....

.....

***/Ч.Раднаабазар/***

***/А.Мөнхбат/***

Нөхөрлөлүүдийн хяналтын ажилтан

Хаяг:

.....

***/Ч.Энхбаатар/***

Утасны дугаар:

Хаяг:

Утасны дугаар:

## ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2017 оны 02 дугаар сарын 16

Дугаар 01

Налайх дүүрэг

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 5.3, 5.5 дахь заалтын дагуу нэг талаас Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) Чойжинсамбуу овогтой Раднаабазар, нөгөө талаас тус дүүргийн 3 дугаар хорооны газарт ашигт малтмал ашиглах А/211 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) Сүмбэрхудаг компанийн захирал Алтанбилэг овогтой Мөнхбат, гуравдагч талаас бичил уурхайн “ . . . . . ” бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Нөхөрлөл” гэх)-ийн ахлагч . . . . . овогтой . . . . . нар харилцан тохиролцож энэхүү хариуцлагын гэрээ (“Гэрээ” гэх)-г байгуулав.

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаас нөхөрлөлд нүүрс олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Компани, Нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэ гэрээгээр зохицуулна.

1.2. Энэхүү гэрээг 2017 оны 02 сарын 16-ны өдрөөс эхлэн нэг жилийн хугацаагаар байгуулав.

### **Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг**

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1.1. Ашигт малтмал олборлосон талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд нөхөрлөлд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

2.1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэж, дүүрэгт татвар төлөгчөөр бүртгүүлж, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх

2.1.3. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. Нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг оролцуулахгүй байхыг шаардах

2.2.2. Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг зориулт бусаар ашиглахгүй байхыг шаардах

2.2.3. Гурвалсан гэрээ байгуулахгүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардах

### **Гурав. Засаг даргын хүлээх эрх, үүрэг**

3.1. Засаг дарга дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Нөхөрлөл гэрээт талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

3.1.3. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээдэд борлуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.2. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөхөрлөл болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах;

3.2.2. Албан татвар төлөхийг нөхөрлөл болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах

3.2.3. Үйл ажиллагааны тайланг хугацаандаа өгөхийн шаардах

### **Дөрөв. Нөхөрлөлийн эрх, үүрэг**

4.1. Нөхөрлөл нь дараах үүргийг хүлээнэ.

4.1.1 Бичил уурхайн ажилтан бүрд бичил уурхайн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан зааварчилгаа өгөх;

4.1.2. Олборлолт явуулсан газарт хүн, мал, техник унаж гэмтэхээс хамгаалсан хаалт, далан байгуулна. Тэсэлгээний цоног, ус зайлуулах суваг, шуудуу, малталт, усан сан зэрэгт таглаа, хаалт хамгаалалт хийх;

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILPDGEREE.MN

4.1.3. Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулна. Өвчтэй буюу эрүүл мэндийн байдлаар ажиллах чадваргүй байгаа ажилтныг тухайн өдөр ажилд гаргахыг хориглох;

4.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

4.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргаас шаардах;

4.2.2. Нөхөрлөлийн гишүүдэд аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгаа явуулахыг Засаг даргаас шаардах

4.2.3. Тусгай зөвшөөрөл олгосон газарт нөхөн сэргээлт хийхэд дэмжлэг туслалцаа авах

#### ***Тав. Харилцан хүлээх үүрэг***

5.1. Гэрээний дагуу олборлолт явуулах явцад тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл нөхөрлөлийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, хүн малд ноцтой хохирол учирвал буруутай тал нь уг хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.

5.2. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

#### ***Зургаа. Гэрээ дуусгавар болох***

6.1. Энэхүү гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

6.1.1. Гэрээний хугацаа дууссан бөгөөд гэрээг сунгаагүй;

6.1.2. Гэрээний хүчинтэй хугацаанд тусгай зөвшөөрөл хүчингүй болох эсхүл хугацаа нь дуусгавар болох;

6.1.3. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал бусад талууддаа бичгээр мэдэгдсэн боловч бусад талууд нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

#### ***Долоо. Бусад зүйл***

7.1. Энэхүү гэрээ нь 2017 оны 02 сарын 16-ны өдрөөс 2018 оны 02 сарын 16-ны өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд гэрээний үүргээ биелүүлснээр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

7.3. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

7.4. Гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

#### ***Найм. Маргаан шийдвэрлэх***

8.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

8.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

#### ***Гэрээ байгуулсан:***

Налайх дүүргийн Засаг дарга

Сүмбэрхудаг компанийн Захирал

.....  
/Ч.Раднаабазар/

.....  
/А.Мөнхбат/

..... нөхөрлөлийн ахлагч

Хаяг:

.....  
/..... /

Утасны дугаар:

Хаяг:

Утасны дугаар: